

ТАНДЭМ ИНВЭСТ ББСБ ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2022 оны 8 сарын 13 өдөр

Дугаар 09

Улаанбаатар хот

Компанийн хаягийн өөрчлөлтийг батлах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх заалт, 62 дугаар зүйлийн 62.1.1 дэх заалт, Тандэм Инвэст ББСБ ХК-ийн 2022 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын тооллогын комиссын дүнг үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Компанийн хаягийн өөрчлөлтийг баталсугай.
2. Компанийн хаягийн өөрчлөлтийг холбогдох хууль тогтоомжид заасан хугацаанд Улсын бүртгэлийн ерөнхий газарт бүртгүүлэх, дүрмийн хувийг Санхүүгийн зохицуулах хороо болон Монголын хөрөнгийн бирж ТӨХК-д хүргүүлж ажиллахыг Гүйцэтгэх захирал (Ж.Ганхүлэг)-д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГАХК



Ч.ЧИНЗОРИГ

ТАНДЭМ ИНВЭСТ ББСБ ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2022 оны 8 сарын 13 өдөр

Дугаар 10

Улаанбаатар хот

Компанийн дүрмийн өөрчлөлтийг батлах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх заалт, 62 дугаар зүйлийн 62.1.1 дэх заалт, Тандэм Инвэст ББСБ ХК-ийн 2022 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын тооллогын комиссын дүнг үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Компанийн дүрмийн шинэчилсэн найруулгыг энэхүү тогтоолын Хавсралт №1-ээр баталсугай.
2. Дүрмийн шинэчилсэн найруулгыг холбогдох хууль тогтоомжид заасан хугацаанд Улсын бүртгэлийн ерөнхий газарт бүртгүүлэх, дүрмийн хувийг Санхүүгийн зохицуулах хороо болон Монголын хөрөнгийн бирж ТӨХК-д хүргүүлж ажиллахыг Гүйцэтгэх захирал (Ж.Ганхүлэг)-д үүрэг болгосугай.
3. Дүрмийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөл, Гүйцэтгэх удирдлагад тус тус үүрэг болгосугай.



Ч.ЧИНЗОРИГ

Тандэм Инвэст ББСБ ХК-ийн ХЭ-ийн 2022 оны 8 дугаар сарын 13-ны өдөр
10 тоот тогтоолын Хавсралт №1



ТАНДЭМ ИНВЭСТ ББСБ ХК-ийн дүрэмд орох өөрчлөлтүүд

Харьцуулалтууд		
Хуучин	Өөрчлөлт	Тэмдэглэл
1.3 Компанийн оршин байгаа газрын хаяг: Монгол улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг 1-р хороо, Баруун сэлбэ 5-3, Аризона төв 1-11 тоот	1.3 Компанийн оршин байгаа газрын хаяг: Монгол улс, Улаанбаатар хот, Баянгол дүүрэг 2-р хороо, Эрхи төв 4-402 тоот	Өөрчлөлт

ТАНДЭМ ИНВЭСТ ББСБ ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2022 оны 8 сарын 13 өдөр

Дугаар 11

Улаанбаатар хот

Компанийн салбар нэгж байгуулах эрх олгохыг батлах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.1 дэх заалт, Тандэм Инвэст ББСБ ХК-ийн 2022 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын тооллогын комиссын дүнг үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Компанийн тогтвортой үйл ажиллагааг хангах үүднээс салбар нэгжүүд байгуулан ажиллахыг ТУЗ-д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГ  Ч.ЧИНЗОРИГ

ТАНДЭМ ИНВЭСТ ББСБ ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2022 оны 8 сарын 13 өдөр

Дугаар 12

Улаанбаатар хот

Компанийн нэмэлт хувьцаа гаргахыг батлах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.1, 62.1.3 дэх заалт, Тандэм Инвэст ББСБ ХК-ийн 2022 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын тооллогын комиссын дүнг үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Компанийн тогтвортой үйл ажиллагааны цар хүрээг тэлэх зорилготойгоор нээлттэй болон хаалттай хүрээнд 491,883,292 ширхэг хүртэлх энгийн хувьцаа нэмж гаргаж, үнэ тогтоох болон холбогдох ажил үүргийг гүйцэтгэхийг ТУЗ-д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГ



Ч.ЧИНЗОРИГ

**ТАНДЭМ ИНВЕСТ ББСБ ХК-ИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ**

Огноо: 2022 оны 8 сарын 13-ны өдөр

Цаг: 10:00

Хэлбэр: Цахим/Zoom/

Хэлэлцэх асуудал:

1. Компанийн хаяг өөрчлөх тухай,
2. Компанийн дүрмийн өөрчлөлтийг батлах
3. Бусад / Компанийн салбар нэгж байгуулах, нэмэлт хувьцаа гаргах тухай

Тооллогын комиссын дарга М.Уянга хурлын ирц танилцууллаа.

Хурлын ирц: 67.2%

Хурлын дарга Ч.Чинзориг 10:01 минутад хурал нээснийг мэдэгдлээ.

Ч.Чинзориг: Сайн байцгаана уу. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал нээснийг мэдэгдэж байна. Хуралд оролцож байгаа хувьцаа эзэмшигчдэдээ баярлалаа. Өнөөдрийн хурлаар хэлэлцэх асуудлуудыг гүйцэтгэх захирал Ж.Ганхүлэг танилцуулна.

Гүйцэтгэх захирал Ж.Ганхүлэг: Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Энэ удаагийн хурлаар 3 асуудлыг хэлэлцэхээр оруулсан байгаа. 1. Компанийн хаяг өөрчлөх, 2. Компанийн дүрмийн өөрчлөлт, 3. Бусад асуудал дотор:

- Салбар нэгжүүд байгуулах
- Финтек бизнест хөрөнгө оруулахтай холбоотой зарласан хувьцаанаас гаргах тухай асуудлуудыг хэлэлцэхээр оруулсан байгаа.

Хэлэлцэх асуудал 1: Компанийн хаяг өөрчлөгдөж байгаатай холбогдуулан компанийн дүрмийг батлуулах,

- Компанийн байрлаж буй Аризона төвийн удирдлага нь цаашид уг обектыг худалдах болсон тухай мэдэгдсэн бөгөөд компанийн үйл ажиллагааг тогтвортой явуулах үүднээс мөн ажлын байрыг компанийн харилцагчид үйлчлүүлэхэд ойр дөхөм байх талаас нь бид хотын төвд шинээр баригдсан Эрхи төвийг сонгосон байгаа. Компанийн дүрмийн 1.3 заалт буюу компанийн хаяг өөрчлөгдөж байгаатай холбогдуулан компанийн шинэчилсэн дүрмийг батлуулахаар та бүхэнд танилцуулж байна.

Та бүхэн компанийн хаяг өөрчлөхтэй холбоотой асууж тодорлуулах зүйл байвал асуугаарай.

За уг асуудал дээр асууж тодорлуулах зүйл байхгүй бол дараагийн асуудлаа танилцуулъя.

Хэлэлцэх асуудал 2: Компанийн салбар нэгж байгуулах тухай,

- Компани 2022 онд хаалттай хүрээнд нэмж үнэт цаас гаргаснаар компанийн хөрөнгө нэмэгдсэн. Үүнтэй холбогдуулан компанийн үйл ажиллагааны цар хүрээг нэмэх, Улаанбаатар хотын дүүрэг бүрийн харилцагчид үйлчлүүлэхэд ойр байх үүднээс салбар нэгж байгуулах тухай саналыг хувьцаа эзэмшигч та бүхэнд танилцуулж байна.

Уг асуудалтай холбогдуулан салбар нэгж байгуулах эрхийг ТУЗ-д олгох тухай саналыг та бүхэн саналын хуудсаараа дамжуулан саналаа өгнө үү.

Асууж тодорлуулах зүйл байна уу.

Хэлэлцэх асуудал 3: Нэмэлт хувьцаа гаргах тухай

- Компани бизнесийн үйл ажиллагааг олон нийтэд хүртээмжтэй байх үүднээс нээлттэй болон хаалттай хүрээнд 491,883,292 ширхэг энгийн зарласан хувьцаа гаргаж финтек технологид суурилсан үйлчилгээнд хөрөнгө оруулалт хийх шаардлага гаргасан. Хөрөнгө оруулалт хийхдээ финтек технологид суурилсан компанитай нэгдэх эсвэл хөрөнгө оруулалт хийж үйл ажиллагаа явуулахаар замаар хэрэгжүүлнэ. Ингэснээр зах зээлийн өрсөлдөөнд хэрэглэгчдийн хэрэгцээ шаардлагад нийцсэн шинэ бүтээгдэхүүн үйлчилгээг нэвтрүүлэх боломж бүрдэх юм. Нэмэлт хувьцаа гаргахтай холбоотой бүхий л төлөвлөгөөт ажлуудыг хийж гүйцэтгэхийг ТУЗ-д хариуцуулж байна.

Хувьцаа эзэмшигч Л.Тунгалаг: Финтек технологи гэж юу байдаг вэ мэдээлэл өгөөч?

Гүйцэтгэх захирал Ж.Ганхүлэг: Санхүүгийн үйлчилгээг зохицуулах технологид суурилсан хэрэглэгчдийн мөнгө байршуулах, хадгалах, зээлэх, хөрөнгө оруулах, шилжүүлэх, төлбөр хийх болон мөнгөө эрсдэлээс хамгаалах хандлагыг өөрчилдөг старт-ап болон компаниудыг финтек гэнэ.

Хувьцаа эзэмшигч: Д.Бадамдулам: Хувьцааны үнийг хэрхэн тогтоох вэ?

Гүйцэтгэх захирал Ж.Ганхүлэг: МХБ болон СХЗ-ны зохих журмуудыг мөрдлөгө болгон үнийг тогтоож өгнө.

Гүйцэтгэх захирал Ж.Ганхүлэг: Хэлэлцэх асуудлуудыг танилцуулж дууслаа. Та бүхэн хэлэлцэх асуудлуудын дагуу саналаа өгнө үү. Саналын хуудасны линкийг чат хэсэгт оруулсан байгаа. Санал өгөх хугацаа 10 минут.


За хуралд оролцсон бүх хүмүүсийн саналын хуудас бүрэн ирсэн байна. Тооллогын комисс санал хураалтын дүнг нэгтгээд та бүхэнд танилцуулах болно. Тооллогын комиссын дүн 10 минутын дараа гарах болно. Та бүхэн түр хүлээнэ үү.

Тооллогын комиссын дарга М.Уянга: Тооллогын комиссын дүн гарч дууслаа. Тандэм Инвэст ББСБ ХК-ийн 2022 оны 8-р сарын 13-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын саналын дүнг танилцуулж байна. Нийт компанийн гаргасан 1,508,838,708 ширхэг хувьцаанаас өнөөдрийн хуралд 1,015,266,193 ширхэг энгийн хувьцаа эзэмшигчид оролцсоноор хурлын ирц 67.2 хувь байна. Санал авсан асуудлуудаар хуралд оролцсон хувьцаа эзэмшигчдийн 100 хувийн саналаар дэмжигдсэн байна.

1. Компанийн хаяг өөрчлөх тухай талаар хуралд ирсэн саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн 100% саналаар, нийт саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн 67,2% саналаар зөвшөөрч баталсан.
2. Компанийн дүрмийн өөрчлөлтийг хуралд ирсэн саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн 100% саналаар, нийт саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн 67,2% саналаар зөвшөөрч баталсан.

3. 3.1. Компанийн салбар нээх эрхтэй холбоотой эрхийг ТУЗ-д өгөх талаар хуралд ирсэн саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн 100% саналаар, нийт саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн 67,2% саналаар зөвшөөрч баталсан.
4. 3.2. Компани нээлттэй болон хаалттай хүрээнд нэмэлт хувьцаа гаргаж, СЗХ, МХБ-н зохих журмыг мөрдлөг болгон үнийг тогтоох болон холбогдох ажлыг ТУЗ-д үүрэг болгох талаар хуралд ирсэн саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн 100% саналаар, нийт саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн 67,2% саналаар зөвшөөрч баталсан.

Ч.Чинзориг: За саналаа өгсөн хувьцаа эзэмшигчид болон хуралд оролцсон төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүддээ баярлалаа. Өнөөдрийн ХЭ-ийн ээлжит бус хурлыг өндөрлөж байгааг мэдэгдье. Баярлалаа

Хурлын тэмдэглэл /Хуралын протокол/  /Б.Бадамцэцэг/
Хурлын дарга   /Ч.Чинзориг/